Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Боловсролын нэгдсэн бодлого, төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч, Б Бадамжав

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.2. Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах | | | | | | | |
| 1 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсрол, шинжлэх ухааны асуудлаар тусгуулах санал боловсруулна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгах санал | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 12 асуудал тусгагдсан. | Төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж өгсөн байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах чиглэлээр ЭЗХЯ-наас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан арга зүйгээр улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь" сургалтад хамрагдаж, сургалтаар өгсөн удирдамж, чиглэлийн дагуу улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг дараах үе шаттай боловсрууллаа. Үүнд: 1. Боловсрол, шинжлэх | 1-р сар, 2-р сар, 3-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ухааны сайдын “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/592 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг батлуулсан. 2. Яамны нэгж, харъяа байгууллагаас санал авч, нэггэн тусгасан. 3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах саналыг БШУЯ-ны 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/168 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 4. ЭЗХЯ-наас зохион байгуулсан 2 удаагийн уулзалтад хуваарийн дагуу оролцож тодруулга, мэдээлэл өгч ажиллалаа. 5. Боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах төсөл, арга хэмжээний талаар танилцуулга, тайлбар зэрэг мэдээллийг 2-5 саруудад тухай бүр өгч, хүргүүлж ажиллалаа. 6. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхэд саналаа тухай бүр албан бичгээр хүргүүллээ.<br>Хавсралт: 6 файл | | |
| 2 | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргана. | Системийн чадавх бэхжүүлэх төслөөр салбарын хүчин зүйлийн шинжилгээ хийж, тэргүүлэх чиглэлийн жагсаалт гарч, Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргасан байна. | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, Төслийн санал | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, салбарын тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байна. Хэрэгжүүлэгч байгууллага /Grant agency/-г сонгосон байна. “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргасан байна. | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргах хүрээнд дараах үе шаттай ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд хамрагдах хүрээнд Дэлхийн банкны олон улсын болон дотоодын зөвлөхүүд салбарын хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Салбарын хүчин зүйлийн шинжилгээний үр дүн, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж, LEG-ийн техникийн хурлыг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, хэлэлцүүллээ. 2. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг”-ийн /LEG/ хандивлагч улс, олон улсын байгууллагын удирдлагын дээд түвшний зөвшилцөх уулзалтыг 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа. Дээд түвний зөвшилцөх уулзалтаар GPE-ийн “Системийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулсан "Шинэчлэлийн тэргүүлэх чиглэл”, салбарын нөхцөл байдлын шинжилгээ /Enabling Factors Analysis/-ний үр дүнг хэлэлцэн, баталлаа. 3. Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах” буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллагыг сонгох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар шинэчлэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллаа. Тус ажлын хэсгээс "Буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллага /grant agent/-ыг сонгон шалгаруулах удирдамж"-ыг боловсруулж, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл” буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон шалгаруууллаа. Буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллага /Grant Agent/-аар ажиллах хүсэлтийг Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан ирүүлж, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээгээр Дэлхийн банк сонгогдож, “Боловсролын олон нийтийн бүлэг” /LEG/-ээр баталгаажууллаа.<br>Хавсралт: 12 файл | | |
| 3 | Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн хуралдаан | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн багийн ажлын | Боловсролын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг | Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны | 1-р сар, 3-р сар, 4-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтын ажиллагааны зохицуулалтыг хангана. | | удирдамж /LEG TOR/ | хэлэлцүүлсэн байна. | зохицуулалтыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг”-ийн /LEG/ хандивлагч улс, олон улсын байгууллагын техникийн болон удирдлагын дээд түвшний зөвшилцөх уулзалтыг зохион байгууллаа. Дээд түвшний зөвшилцөх уулзалтаар GPE-ийн “Системийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулсан "Шинэчлэлийн тэргүүлэх чиглэл”, салбарын нөхцөл байдлын шинжилгээ /Enabling Factors Analysis/-ний үр дүнг хэлэлцэн, баталлаа. 2. Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах” буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллагыг сонгох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30- | | даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрийн А/199 дүгээр тушаалаар шинэчлэн баталлаа. Тус ажлын хэсгээс "Буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллага /grant agent/-ыг сонгон шалгаруулах удирдамж"-ыг боловсруулж, “Системийн чадавхыг сайжруулах төсөл” буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон шалгаруулллаа. Буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллага /Grant Agent/-аар ажиллах хүсэлтийг Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан ирүүлж, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээгээр Дэлхийн банк сонгогдож, “Боловсролын олон нийтийн бүлэг” /LEG/-ээр Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл” буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгаруулалтыг баталгаажууллаа. 3. Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй PISA нэмэлт шинжилгээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн хурал, үйл ажиллагааг зохион байгууллаа. 4. Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр хэрэгжүүлэх төслийн дизайн боловсруулахад шаардлагатай холбогдох мэдээлэл судалгаагаар хангав. Хавсралт: 3 файл | | |
| 4 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсролын салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | Төслийн дизайн | - | - | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсролын салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, ажиллалаа. Тус төслийн үзэл баримтлал батлагдаж, төслийг хэрэгжүүлэгч сургалтын байгууллагыг сонгох судалгаа хийх чиглэлээр АХБ-ны ахлах мэргэжилтэн Хёнжү Юн Монгол Улсад ажиллаж, 157, 159, Орчлон сургуулийн STEAM, байгалийн ухааны лаборатори, Мэдээлэл | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйн анги, танхимтай танилцаж, төсөл хэрэгжүүлэх сургуулийг судлах, холбогдох мэдээллийг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Хавсралт: 4 файл | | |
| 5 | Боловсролын салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох эрх зүйн баримт бичиг, шийдвэр, зохицуулалтын төсөл боловсруулна. | Судалгаа, тушаал, шийдвэрийн төсөл | - | Хийгдсэн судалгаа, тушаал, шийдвэр | 2024 оны эхний хагас жилд боловсролын салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох эрх зүйн баримт бичиг, шийдвэр, зохицуулалтын төсөл боловсруулж, батлууллаа. Тухайлбал: 1. Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд орон нутагт Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ, Засаг дарга нарын 2024 онд шалгуур, зорилтод түвшний матрицыг холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн боловсруулаа. 2. Засгийн газрын хуралдаанд Монголын үндэсний өв уламжлал, шашны соёл, гүн ухааныг хадгалж, хамгаалж, хөгжүүлэх шаардлагыг харгалзан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Бурхан шашны дээд сургууль”-ийг “Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурханы шашны их сургууль” болгон өргөжүүлэх асуудал болон тус сургуулийн дэргэдэх ерөнхий боловсролын сургуулийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцүүлж, Засгийн газрын тогтоол гарлаа. 3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан боловсролын салбарын зорилго, зорилтын хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах холбогдох арга хэмжээний талаар контент бэлтгэх, түүнийг түгээх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/33 дугаар тушаалаар батлууллаа. 4. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан “Монгол Улсын бүсчилсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжил - Боловсролын салбар" сэдэвт онлайн уулзлатыг зохион байгуулж, форумд оролцож, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд санал боловсруулж хүргүүллээ. 5. Ерөнхий боловсролын сургуулийн "Сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт"-ыг үндэслэн Mlab.02 цахим платформд сургалтын хэрэглэгдэхүүний нэгдсэн бүртгэлийг хийхэд шаардагдах зардлыг батлууллаа. 6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Монголын багш нарын VIII дугаар их хурлын холбогдох баримт бичиг, мэндчилгээ, илтгэл, тогтоолын төсөл зэргийг БНБТГ-аас боловсруулж, батлуулж, зохион байгуулах бэлтгэл хангаж оролцлоо.<br>Хавсралт: 9 файл | | |
| 6 | Бүх түвшний боловсролын сургалтын | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Улсын бүртгэл, тусгай зөвшөөрөлийн | Оролцогч талын төлөөлөл бүхий ажлын хэсгийг | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 27- | 1-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын оноосон нэр, хуулийн этгээдийн бүртгэлийг шинэчлэх арга хэмжээ авна. | | талаарх мэдээлэл, судалгаа | байгуулж, тодорхой арга хэмжээ авсан байна. | ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/580 дугаар тушаалаар байгуулагдсан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын оноосон нэр, хуулийн этгээдийн бүртгэлийг тодорхой болгохтой холбогдох ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл, улсын бүртгэлийн тулгалтыг УБЕГ-тай хамтран хийлээ. Энэхүү ажлын хүрээнд сургалтын байгууллагын гэрчилгээг шинэчлэх ажил хийгдэх явцад гарсан зарим асуудлыг ажлын хэсэг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Орон нутгийн зарим политехникийн коллеж, МСҮТ-ийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэхдээ "Төрийн байгууллага, албан газар" гэж бүртгэснийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас орон нутгийн бүртгэгч нарт чиглэл өгүүлж, үнэ төлбөргүй дахин олгох ажлыг зохион | | Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллаа. Улсын бүртгэлийн гэрчилгээг боловсрол сургалтын байгууллага /БСБ/ гэж бүртгэлийг шинэчилсэн. Хавсралт: 8 файл | | |
| 7 | Боловсролын үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Ажлын албаны чиг үүргийн хэрэгжилт | - | Ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Боловсролын үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Боловсролын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Зардал батлах тухай" А/58 дугаар тушаалаар батлууллаа. 2. Боловсролын ерөнхий хуулийн 23.1, 23.4-д заасан Боловсролын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгууллаа. Хуралдаанд Боловсролын үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Боловсролын үндэсний зөвлөлийн дэд дарга, Боловсрол, шинжлэх | 3-р сар, 4-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ухааны сайд Л.Энх-Амгалан нар оролцож, 72.3 хувийн ирцтэй хуралдлаа. Боловсролын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал", "Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын "PISA-2022" үнэлгээний Монгол Улсын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулж хэлэлцүүллээ. Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдаанаас гарсан тэмдэглэлд "1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжиж, 2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагаас зохион байгуулсан суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын "PISA-2022" үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн үр дүн, цаашид авах арга хэмжээг дэмжлээ.<br>Хавсралт: 14 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Боловсролын асуудлаар гарч буй олон улсын судалгааны ажил, өгүүллэг уншиж мэдлэгээ дээшлүүлэх | UNESCO, OECD зэрэг олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар гарч байгаа бодлогын зөвлөмж, гарын авлагыг уншиж | Олон улсын байгууллагаас гаргасан сэтгүүл, судалгааны тайлан | Англи хэл дээр уншиж судалсан ном, гарын авлага (тоогоор) | Боловсролын асуудлаар гарсан дараах судалгааны тайлан, мэдээллийг уншиж танилцлаа. 1. Making the teacher policy 2. United Nation SD cooperation framework 2023-2027 3. UN Mongolia Annual Result Report 2023 | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | судлах. | | | Хавсралт: 3 файл | | |
| 2 | Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах. | Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, сан үүсгэх. | Өдөр тутам албан хэрэгцээнд ашигладаг хууль тогтоомж | Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр | Дараах хуулийн төслүүдийг уншиж танилцаж, заримд нь санал өглөө. - Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулага - Даатгалын тухай хууль, Даатгалын зуучлалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл<br>Хавсралт: 3 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын нэгдсэн бодлого, төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч, Б Бадамжав /................................................./ Огноо: .........................